



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

Цуврал №7

2015 оны 3 дугаар улирлын байдлаар

Эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн бодит өсөлт 2015 оны эхний 3 улирлын урьдчилсан гүйцэтгэлээр **2.5** хувьтай гарлаа. Уг өсөлт нь уул уурхай, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын өсөлтөөр голлон тайлбарлагдаж байна.

Хүснэгт 1. 2015 оны эхний 3 улирлын бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)

	Бодит ДНБ	2.5%	100.0%
1 Хөдөө аж ахуй	1.3%	52.0%	
2 Уул уурхай, олборлолт	3.0%	118.7%	
3 Боловсруулах үйлдвэрлэл	0.2%	6.7%	
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.0%	1.4%	
5 Барилга	-0.5%	-21.2%	
6 Бөөн/жиж.худалдаа	-0.8%	-31.4%	
7 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-0.5%	-18.8%	
8 Мэдээлэл, холбоо	0.1%	4.5%	
9 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.8%	69.0%	
10 Бүтээгдэхүүний цэвэр татвар	-2.1%	-80.8%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.


Харин бөөний болон жижиглэн худалдаа 6.1 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 16.5 хувь, барилга 13.2 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 7.8 хувиар тус тус буурчээ.

Хүснэгт 2. ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)

	Салбарууд	2014.Q1-3	2015.Q1-3
	Бодит ДНБ	8.9%	2.5%
1 Хөдөө аж ахуй	25.0%	9.8%	
2 Уул уурхай, олборлолт	20.8%	14.4%	
3 Боловсруулах үйлдвэрлэл	4.7%	3.1%	
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3.0%	2.1%	
5 Барилга	-8.3%	-13.2%	
6 Бөөн/жиж.худалдаа	5.2%	-6.1%	
7 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.5%	-7.8%	
8 Мэдээлэл, холбоо	7.0%	4.5%	
9 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11.4%	8.7%	
10 Бүтээгдэхүүний цэвэр татвар	-9.3%	-16.5%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Дүрслэл 1. Эдийн засгийн өсөлтийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тэмдэглэл: *2015 оны урьдчилсан гүйцэтгэл

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 9-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс **4.9** хувиар, Улаанбаатар хотын индекс **3.9** хувиар тус тус өсөв.

Дүрслэл 2. Инфляцийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Улаанбаатар хотын 9 дүгээр сарын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл -32.5 хувийг (-1.3 нэгж хувь) мах, 22.4 хувийг (0.9 нэгж хувь) махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 11.1 хувийг (0.4 нэгж хувь) хувцас, 25.7 хувийг (1.0 нэгж хувь) орон сууц, ус, түлш, цахилгааны үнийн өсөлт бүрдүүлсэн бол үлдсэн 73.3 хувийг (2.9 нэгж хувь) бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр үргэлжлэн буурч байгаа бол импортын барааны инфляци алгуур саарч байна. Инфляци зорилтот түвшинтэйгээ нийцтэй болж буурч буй нь инфляцид нөлөөлөх ханшийн нөлөөлөл буурсаар байгаатай холбоотой юм.

Дүрслэл 3. Инфляцийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2015 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 172.4 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл 345.3 сая ам.долларын ашигтай, харин урсгал данс 412.7 сая ам.долларын алдагдалтай гарав.

Дүрслэл 4. Төлбөрийн тэнцэл




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *2015 оны урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2015 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр -4.8 хувь болоод буураад байна.

Дүрслэл 5. Урсгал тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *2015 оны урьдчилсан гүйцэтгэл.

Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2015 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 71.8 хувиар буурч -412.7 сая ам.долларт хүрчээ.

Барааны гадаад худалдааны ашиг 3.0 дахин өсч, 950.0 сая ам.долларт хүрсэн, үйлчилгээний тэнцлийн алдагдал 1.9 дахин буурч, 632.9 сая ам.долларт хүрсэн зэрэг нь урсгал тэнцэл ийнхүү сайжрах суурь нөхцөл болов.

Дүрслэл 6. Урсгал тэнцлийн санхүүжилт




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *2015 оны урьдчилсан гүйцэтгэл.

Хөрөнгө, санхүүгийн дансны ашиг тайлант хугацаанд 59.5 хувиар буурч, 345.3 сая ам.долларт хүрчээ. 2013 оны 10 дугаар сард хөрөнгө оруулалтын урт хугацааны тогтвортой орчинг бүрдүүлэх багц хуулийг УИХ-аас баталсан хэдий ч, Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт 2015 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 98.1 хувиар буюу 516.3 сая ам.доллараар буурав.


Дүрслэл 7. Хөрөнгө, санхүүгийн дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *2015 оны урьдчилсан гүйцэтгэл.


Дүрслэл 8. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *ДНБ-ий 2015 оны 3 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэл ашиглав.

Дүрслэл 9. Гадаад худалдааны тэнцэл (с.и.ф нөхцөлөөр, сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Гадаад валютын улсын нөөц (ГВУН)

ГВУН нь 2015 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оноос 8.4 хувиар буюу 130.0 сая ам.доллараар буурч **1412.7** сая ам.долларт хүрлээ.

Валютын төлбөртэй импортын дүн буурснаар импортын хэрэгцээг хангах ГВУН-ийн түвшин 4.6 сард хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 1.1 нэгжээр илүү байна.

Дүрслэл 10. Гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Импортын хэрэгцээг хангах түвшинг ГВУН-ийг валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж үзүүлэлтэд харьцуулж тооцов.

Гадаад худалдааны нөхцөл

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2012 оны суурьтай) 2015 оны 9 дүгээр сард **1.25**-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **21.2** хувиар буурав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс буурахад экспортын үнэ импортын үнийн индексээс илүү хурдацтай буурсан нь нөлөөлжээ.

Дүрслэл 11. Гадаад худалдааны нөхцөлийн индекс




Эх сурвалж: Монголбанк.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2013, 2014 оны мөн үед харгалзан 18.1%, 11.8%-иар тус тус суларч байсан бол 2015 оны 9-р сарын эцэст өмнөх оны мөн үеэс **8.5** хувиар суларч, **1,993.8** төгрөгт хүрч тогтворжоод байна.

Харин гадаад худалдааны голлох түнш орнуудын валютын ханштай харьцуулсан нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) **6.5** хувиар, инфляцийн зөрүүг оруулан тооцсон бодит үйлчилж буй ханш (REER) **8.5** хувиар тус тус чангарсан байна.

Дүрслэл 12. Гадаад валютын ханш (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.

Улсын төсөв

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 2015 оны эхний 9 сарын байдлаар **4,048.2** тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн **4,913.2** тэрбум төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэл **1,290.6** тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Нэгдсэн төсвийн орлогын тасралтад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын гүйцэтгэл **65.6** тэрбум төгрөг, импортын барааны НӨАТ **263.2** тэрбум төгрөг, суудлын автомашины онцгой албан татвар **39.2** тэрбум төгрөг, импортын гаалийн албан татвар **55.8** тэрбум төгрөг, газрын тосны орлого **82.3** тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлого **166.3** тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Жилийн төлөвлөгөө	2015 оны эхний 9 сар			
		*	**	**/*	***
Нийт орлого ба тусламжийн дүн	6 662	4 857	4 048	83%	-7%
Тогтворжуулалтын сан	30	23	2	10%	-95%
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6 633	4 834	4 046	84%	-6%
<i>I. Татварын орлого</i>	<i>5 400</i>	<i>3 960</i>	<i>3 500</i>	<i>88%</i>	<i>-5%</i>
1. Орлогын албан татвар	1 151	812	710	87%	1%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	652	443	377	85%	0%
1.2. Хүн амын орлогын албан татвар	541	399	365	91%	11%
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 236	769	759	99%	10%
3. Өмчийн татвар	83	70	66	94%	100%
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1 887	1 442	1 179	82%	-15%
4.1. Нэмэгдсэн өргийн албан татвар	1 254	967	760	79%	-25%
4.2. Онцгой албан татвар	621	467	411	88%	19%
4.3. Тусгай зориулалтын орлого	12	8	9	107%	-74%
5. Гадаад худалдааны орлого	377	297	241	81%	-12%
6. Бусад татвар	667	569	544	96%	-4%
<i>II. Татварын бус орлого</i>	<i>1 233</i>	<i>874</i>	<i>546</i>	<i>62%</i>	<i>-15%</i>
1. Хөрөнгийн орлого	183	183	17	9%	-
2. Тусламжийн орлого	63	48	15	32%	-

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *Төлөвлөгөө, **Урьдчилсан гүйцэтгэл, ***Жилийн өсөлтийн хувь.

Нэгдсэн төсвийн орлогын тасралтад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын гүйцэтгэл **65.6** тэрбум төгрөг, импортын барааны НӨАТ **263.2** тэрбум төгрөг, суудлын автомашины онцгой албан татвар **39.2** тэрбум төгрөг, импортын гаалийн албан татвар **55.8** тэрбум төгрөг, газрын тосны орлого **82.3** тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлого **166.3** тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлжээ.

Төсвийн зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс **9.1** хувиар буюу **409.1** тэрбум төгрөгөөр өсч **4,913.2** тэрбум төгрөгт хүрч, **80.2** хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн зарлага	Жилийн төлөвлөгөө	2015 оны эхний 9 сар			
		*	**	**/*	***
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7 837	6 124	4 913	80%	9%
Урсгал зардал	5 823	4 378	4 031	92%	11%
1. Бараа, үйлчилгээний зардал	2 899	2 249	1 967	87%	8%
1.1. Цалин хөлс	1 806	1 294	1 246	96%	11%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	170	121	114	95%	9%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	923	835	606	73%	2%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	696	429	397	93%	53%
3. Татаас ба шилжүүлэг	2 227	1 699	1 667	98%	6%
Хөрөнгийн зардал	2 015	1 712	861	50%	1%
1. Дотоод эх үүсвэрээр:	1 786	1 540	732	48%	-3%
2. Гадаад эх үүсвэрээр:	229	172	129	75%	35%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	0	35	21	61%	185%
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-1 205	-1 291	-867	67%	351%


Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *Төлөвлөгөө, **Урьдчилсан гүйцэтгэл, ***Жилийн өсөлтийн хувь.

Төсвийн урсгал зардал өмнөх оны мөн үеэс **10.5** хувь буюу **384.0** тэрбум төгрөгөөр өсч **4,031.3** тэрбум төгрөгт, хөрөнгийн зардал **1.3** хувиар буюу **11.4** тэрбум төгрөгөөр өсч **860.9** тэрбум төгрөгт, эргэж төлөгдөх цэвэр зээл **184.6** хувиар буюу **13.7** тэрбум төгрөгөөр өсч **21.1** тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

2015 оны эхний 9 сарын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл **867.3** тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ий **-5.2** хувьтай тэнцэж байна.

Дүрслэл 13. Нэгдсэн төсвийн тэнцэл (жил бүрийн эхний 9 сарын байдлаар)




Эх сурвалж: Сангийн яам.

Мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүд

M2 мөнгийг актив талаас нь авч үзэхэд 2015 оны 9 дүгээр сарын байдлаар дотоод цэвэр авлага өмнөх оны мөн үеэс **12.1** хувиар буюу **1.6** их наяд төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 14. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа (актив тал)



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: *ОСИСТБ хөтөлбөрийн зээлийн нөлөөллийг хасч тооцсон дүн болно.

Харин гадаад цэвэр актив 2015 оны 9 дүгээр сарын байдлаар **-3.7** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **2.8** их наяд төгрөгөөр буурчээ. Дотоод цэвэр актив гадаад цэвэр активын бууралтыг нөхөхүйц хэмжээнд хүрч өсөөгүй тул M2 мөнгөний жилийн өсөлт **-1.4** хувьтай буюу бууралттай гарлаа.

Пассив талаас нь авч үзвэл M2 мөнгөний өсөлтийн -0.3 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 3.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -2.2 нэгж хувийг гадаад валютын харилцах, -2.2 нэгж хувийг M1 мөнгөний бууралт тус тус тайлбарлаж байна.


2014 оны эцэст мөнгөний нийлүүлэлтийн -16.0 хувийг эзэлж байсан гадаад цэвэр актив 2015 оны 6 сарын байдлаар -37.7 хувьд хүрч буурчээ. Ийнхүү M2 мөнгөний нийлүүлэлт дэх гадаад цэвэр активын огцом бууралтыг бий болгосон гол хүчин зүйл нь 2012 оноос эхтэй төлбөрийн тэнцлийн хүндрэл юм.

Дүрслэл 15. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа (пассив тал)



Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 16. Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага




Эх сурвалж: Монголбанк.

Банкны салбарын зарим үзүүлэлтүүд

2013 оны эхний хагас хүртэл тогтмол сайжирч байсан чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2015 оны 3 дугаар улиралд 7.0 хувь болж өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар өсөв.

Дүрслэл 17. Чанаргүй зээлийн харьцаа (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *Татан бугдсан банкуудыг хасч тооцов.

Чанаргүй зээлийн харьцаа уул уурхайн салбарт 23.5 хувь, бөөний болон жигжлэн худалдааны салбарт 12.3 хувьтай байгаа нь дунджаас өндөр байгаа юм. Харин Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол дээрх харьцаа 5.1 хувьтай байв.

Дүрслэл 18. Зээлийн өсөлтийн задаргаа, чанаргүй зээлийн харьцаа




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *ОСИСТБ хөтөлбөрийн зээлийн нөлөөллийг хасч тооцсон дүн болно.

2015 оны 3 дугаар улирлын байдлаар хадгаламжийн байгууллагуудын зээлийн өрийн үлдэгдэл 11.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар буурав. Энэ бууралтын -2.1 нэгж хувийг аж ахуйн нэгжид олгосон зээл, -3.6 нэгж хувийг иргэдийн зээл, үлдсэн 0.3 нэгж хувийг бусад салбар эзэлж байна.

Чанаргүй зээл ба нийт зээлийн харьцаа иргэдийн зээлийн хувьд 2010 оноос хойш тогтмол буурсаар 2014 оны 6 дугаар сард 0.9 хувьд хүрч байсан бол энэ оны 9 дүгээр сард 2.4 хувьтай байна.


Дүрслэл 19. Иргэдийн зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Жижиг дунд үйлдвэрлэл.

Нийт зээлийн **44.6** хувийг эзэлж буй иргэдийн зээл 2015 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс **7.9** хувиар буурчээ.


Дүрслэл 20. Иргэдийн зээлийн бүтэц (2015 оны 3 дугаар улирлын байдлаар)



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Жижиг дунд үйлдвэрлэл.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт банкны системийн хэмжээгээр 2015 оны 3 дугаар улиралд 17.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өсчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагаас 5.3 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.


Дүрслэл 21. Өөрийн хөрөнгө



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Өөрийн хөрөнгө.

Харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт банкны системийн хэмжээгээр 2015 оны 3 дугаар улиралд 34.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагаас 9.6 нэгж хувиар өндөр байна.


Дүрслэл 22. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.


Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсч, инфляцийн түвшин 8.1 нэгж хувиар буурснаар 2014 оны 9-р сард сөрөг 0.7 байсан хадгаламжийн бодит хүү тайлант хугацааны эцэст эерэг 8.2 хувьд хүрээд байна.

Дүрслэл 23. Банкны хадгаламж, зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Хөтөлбөрийн зээлийг оруулсан болно.

Дүрслэл 24. Хүүний динамик



Эх сурвалж: Монголбанк.